

АГУУЛГА

НЭГ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
2025 ОНЫ УУРХАЙН АЖЛЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ	6
Ордын товч танилцуулга.....	5
2025 онд үйл ажиллагаа явуулсан хугацаа.....	6
2025 оны уулын ажлын гүйцэтгэл	7
Дэд бүтэц	6
2025 оны ус ашиглалтын мэдээ	4
2.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	13
2.2. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	39
2.3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	42
2.4. Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө.....	50
2.5. Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох төлөвлөгөө	50
2.6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	50
2.7. Хог хаягдлын менежмент	56
2.8. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	65
ГУРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	68
Агаарын чанар.....	68
Усны хяналт-шинжилгээний үр дүн.	72
ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОН НУТАГТ ТАЙЛАГНАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ	73
ХАВСРАЛТ МАТЕРИАЛ	74

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1- Аж ахуй нэгжийн товч мэдээлэл.....	4
Хүснэгт 2. Ашиглалтын технологийн схем	5
Хүснэгт 3. Уурхайн 2025 онд уурхайн ажиллах хугацаа	6
Хүснэгт 4. 2024 онд унд ахуйн хэрэглээнд ашигласан усны тооцоо.....	6
Хүснэгт 5. Ногоон байгууламжын усалгаанд ашигласан усны хэрэглээ	10
Хүснэгт 6- Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах төлөвлөгөө	13
Хүснэгт 7- Хөрсөн бүрхэвч, гадаргын хэлбэрт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө	27
Хүснэгт 8- Гадаргын болон газрын доорх усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах төлөвлөгөө.....	32
Хүснэгт 9- Ургамал ба амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах төлөвлөгөө	35
Хүснэгт 10- Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд төлөвлөсөн ажил	39

Хүснэгт 11- Нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө	42
Хүснэгт 12- “Тэр бум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд төлөвлөсөн ажил	48
Хүснэгт 13- Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт	50
Хүснэгт 14- Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	56
Хүснэгт 15- Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	65
Хүснэгт 18- 2025 БОМТ-ний Биелэлтийн ажилд шаардагдсан нийт зардал	73

ЗУРГИЙН ЖАГСААЛТ


Зураг 1. Төслийн байршлын зураг	4
Зураг 2. Уулын ажил явагдаж буй байдал	Error! Bookmark not defined.
Зураг 3. Тоолуур суурилуулах байгууламж бэлдэж тог цахилгааныг шийдсэн, тэн байрлуулсан.	Error! Bookmark not defined.
Зураг 4. Зам усалгааны ажлын бүртгэл.....	Error! Bookmark not defined.
зураг 5. Зам усалгааны ажлыг баталгаажуулсан фото зураг	9
Зураг 6. Замын усалгааны бүртгэлийн хуудас, зам усалгааны ажлын зураг	16
Зураг 7. Агаарын бохирдлын хяналтын цэгийн байршил.....	17
Зураг 8. Агаарын тоосжилтын хэмжилтийн ажлын зураг.....	18
Зураг 9. Зам засварын ажлын зураг (замын урт 2.4 км)	19
Зураг 10. Тээврийн хэрэгсэл хүлээлцэх акт бүртгэсэн байдал	20
Зураг 11. Техникийн үзлэг шалгалтын ажлын зураг	21
Зураг 12. Хурдны хязгаар тогтоосон тэмдэг нэмж байршуулсан ажлын зураг	22
Зураг 13.	23
Зураг 14.	24
Зураг 15. Уурхайд ашиглаж буй тоосноос хамгаалах маск	26
Зураг 16. Шимт хөрсний овоолгыг хэлбэршүүлж тэмдэгжүүлсэн ажлын зураг	28
Зураг 17. ШТС-ын нөөцлүүр савыг газарт булж стандартын дагуу тохижуулсан ажлын зураг	30
Зураг 18. Засвараас гарсан хог хаягдал хадгалах хэсгийг тэмдэгжүүлсэн ажлын зураг.....	31
Зураг 19. Хөрсний бохирдол сэдвээр зохион байгуулсан сургалтын ажлын зураг.....	32
Зураг 20. Тоолуур суурилуулсны дараа хөлдөхөөс сэргийлж байгууламж бэлдэн, тог цахилгааныг шийдсэн, тен байрлуулсан байдал.....	34
Зураг 21. Зэрлэг амьтдад өвс, тэжээл тавьж өгөх арга хэмжээг хэрэгжүүлсэн ажлын зураг ...	36
Зураг 22. Уурхайн зогоон руу орсон малыг хөөж гаргасан ажлын хавсаргав.	37
Зураг 23. Сургалтанд хамрагдсан ажилчдын нэрс.....	37
Зураг 24. Булгийн хашааны анхны байдал	40
Зураг-25. 2023 онд булгийг хашаалсан хашааны зураг, 2025 оны 09-р сарын 26-ний байдлаар	40
Зураг 26. Булгийн эхийг шинэчлэн хашаалсан хашааны зураг.....	41
Зураг 27. Шимт хөрсний овоолгыг хэлбэржүүлэн тэмдэгжүүлсэн ажлын зураг	43
Зураг 28. Нөхөн сэргээлтийн туршилт судагааны талбай байгуулахаар төлөвлөсөн газрын байршил	48
Зураг 29. Хөрс бэлтгэсэн ажлын зураг.....	49
Зураг 30. Модны суулгацаа тарьж буй ажлын зураг	49
Зураг 31. Мод усалгааны ажлын зураг.....	50
Зураг 32. Кемпийн гадна байрлуулсан галын сарайн зураг	53
Зураг 33. ХАБ-ын аюулгүй ажиллагааны зааварчилгаанд ажилчдыг хамруулж буй ажлын зураг	53
Зураг 34. Анхан тусламжын эмийн сангийн зураг	54
Зураг 35.	56
Зураг-36. Зохион байгуулсан сургалтын ажлын зураг	58
Зураг 37. Сумын хог хаягдлын нэгдсэн цэгт хог хаягдал хүргэсэн ажлын зураг	59

Зураг 38. Тос масло мэргэжлийн байгууллагад хүлээлгэн өгсөн ажлын зураг	60
Зураг 39. Аюултай хог хаягдал устгалын акт.....	61
Зураг 40. Үүссэн хог хаягдал бүртгэлийн дэвтэр	61
Зураг 41. Дахивар хог цуглуулах хогийн сав байрлуулсан байдал.....	62
Зураг 42. Дээж авах цэгийн байршлыг харуулсан зураг	66

НЭГ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Манай “Биг могул коул энд энерги” ХХК /РД: 5369223/ нь Дундговь аймгийн Баянжаргалан сумын Энгэр-Ус багийн нутаг дэвсгэрт орших ашигт малтмал ашиглалтын MV-020772 тоот дугаартай “Хөөтийн хонхор”-2 нэртэй нүүрсний ордод 2017 оноос эхлэн үйл ажиллагаа явуулж байна.

“Хөөтийн хонхор-2” нүүрсний орд газар нь Улаанбаатар хотоос 330 км, Чойроос 110 км, Баянжаргалан сумын төвөөс 25 км-ийн зайд тус тус байрлана. Талбайн нийт хэмжээ 1046.73 га.



Зураг 1. Төслийн байршлын зураг

Хүснэгт 1- Аж ахуй нэгжийн товч мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр	“Биг могул коул энд энерги” ХХК
Регистрийн дугаар	5369223
Улсын бүртгэлийн дугаар	9011665117
ААН-ийн үйл ажиллагааны чиглэл	Уул уурхай
Тусгай зөвшөөрлийн дугаар	MV-020772
ААН-ийн хаяг	Улаанбаатар хот, СБД, 4-р хороо, Цэнтрүүм оффис, 4 давхар, 401 тоот
Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангын хаяг	Байгаль орчны мэргэжилтэн Г.Бадамгарав, 80821128, gbadmaa1128@gmail.com

ОРДЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн MV-020772 тоот дугаартай “Хөөтийн хонхор”-2 нэртэй ордыг анх 2014 онд ашигт малтмалын нөөцийн улсын бүртгэлд бүртгүүлсэн бөгөөд 2017 оноос олборлолтын үйл ажиллагаа явуулж эхлэсэн.

Ордын 2023 онд хийгдсэн ТЭЗҮ-д тусгаснаар Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2013 оны 12-р сарын 24-ний өдрийн ХХ-24-07 тоот дүгнэлтээр Хөөтийн хонхор-2 талбай дахь нийт бодитой болон боломжтой (B+C) зэргийн цэвэр нүүрсний нөөцийг 18,191.21 мян.тн-оор, чулууны үетэй нүүрсний нөөцийг 19,869.87 мян. тн-оор, үүнээс эдийн засгийн үр ашигтай бодитой (B) зэргийн цэвэр нөөц 7,189.31 мян.тн-оор, чулууны үетэй нүүрсний нөөцийг 7,835.32 мян. тн-оор, эдийн засгийн үр ашигтай боломжтой (C) зэргийн цэвэр нүүрсний нөөцийг 10,750.26 мян.тн-оор, чулууны үетэй нүүрсний нөөцийг 11,899.34 мян.тн-оор баталжээ. Үүнээс 2021 оны эцсийн тайлангаар үлдэгдэл нөөцийн хэмжээ бодитой (B) зэргээр 6,874.14 мян.тн, боломжтой (C) зэргээр 10,661.11 мян.тн болсон байна.

Орд ашиглалтын технологи

“Хөөтийн хонхор”-2 нүүрсний талбайн нөөцийн нүүрсний давхрааснууд нь газрын гадаргууд харьцангуй ойр тул ил уурхайн аргаар авто тээвэртэй, гадаад овоолготой ашиглалтын системээр олборлоно.

Хүснэгт 2. Ашиглалтын технологийн схем

Ашиглалтын систем	Үндсэн ажил	Технологийн процессууд
Тээвэртэй ашиглалтын технологи	1. Хөрс хуулалт	• Өрөмдлөг тэсэлгээ
		• Ухаж ачих
		• Тээвэрлэх
		• Олборлох
	2. Олборлолт	• Ухаж ачих
		• Тээвэрлэх
		• Овоолох

ДЭД БҮТЭЦ


Зам харилцаа.

Хөөтийн хонхор-2 төслийн талбай нь Улаанбаатар хотоос зүүн-урагш 340 км-т Баянжаргалан сумын нутагт орших бөгөөд Дундговь аймгийн Мандалговь хотоос зүүн урагш 130 км, Баянжаргалан сумаас баруун зүгт 25 км-т байрлана. Уурхайн талбайд жилийн аль ч улирал Баянжаргалан сум юм уу аймгийн төв Мандалговь хотоос шороон замаар очих боломжтой.

Барилга байгууламж.

Уурхай нь анх 2018 онд нийт 100 хүний багтаамжтай ажилчдын хотхон барьж байгуулсан бөгөөд 2023 онд кемпийн байгууламжыг өргөжүүлж, нэмэлтээр 60 хүний багтаамжтай сендвичэн барилгыг ашиглалтанд оруулсан байна.

Одоогийн байдлаар уурхайн хотхон нь 60–70 хүний багтаамжтай гал тогооны барилга, ажилчдын амралтын байр, автомашины зогсоол, тамхи татах цэг болон 2025 онд шинээр ашиглалтад орсон автомашины гараж зэрэг барилга байгууламжуудаас бүрдэж байна.



Зураг 2- Кемпийн байгууламжын зураг

Цахилгаан хангамж.

“Хөөтийн хонхор-2” уурхайн ойролцоо “МАК” ХХК-ийн татсан 35/10 кВ-ын өндөр хүчдэлийн шугамд холбогдсон байдаг. Уурхайн цахилгааны хэрэглээг “МАК” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу хангадаг.

Усан хангамж.

Уурхайн ашиглалтын үед унд ахуйн усны хэрэгцээг тусгай зөвшөөрлийн талбайд гаргасан 1.1 л/с ундаргатай гүний худгаас хангана. Зам талбайн усалгаа болон ногоон байгууламжийн усалгааг уурхайн карьерт орж ирэх шүүрлийн усаар хангана.

Хөөтийн хонхрын уурхайн баруунд урд хэсэгт 25 орчим гүнээс газрын доорх ус шүүрч уурхайн олборлолтыг зогсоож, карьерын зүүн талын мөргөцгөөс олборлолт явуулж байна.

Олборлолтын явцад үүссэн шүүрлийн усыг зумпын аргаар соруулж уурхайн карьераас 2.5 км зайд байгальд задгай байдлаар шингээж байна.

ХОЁР. 2025 ОНЫ УУРХАЙН АЖЛЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

2025 онд үйл ажиллагаа явуулсан хугацаа.

Уурхай нь нийтийн баяр ёслолын өдрүүд, цаг агаарын саатал болон засвар үйлчилгээ хийх өдрүүдээс бусад үед жилийн дөрвөн улирал тасралтгүй, хоногт 2 ээлжээр, ээлжинд 12 цагаар ажиллана.

Уурхай нь 2025 оны 07-р сарын 01-ний өдрөөс 08-р сарын 30-ний өдөр хүртэл буюу нийт 61 хоног үндэсний их баяр наадмын амралт болон ажилчдын ээлжийн амралттай холбоотойгоор зогссон бөгөөд уурхай зогссон нь үнэн болох тухай орон нутгаас албан тодорхойлолтоор баталгаажуулсан байна.

2025 онд уурхай нь нийт 304 хоног, 7296 цаг тасралтгүй үйл ажиллагаа явуулсан байна. /үлдсэн хугацаанд зогсохгүйгээр ажилласан тохиолдолд/

Хүснэгт 3. Уурхайн 2025 онд уурхайн ажиллах хугацаа

№	Үзүүлэлтүүд	Утга
1.	Жилийн календарчилсан хоногийн тоо	365
2.	Уурхайн амарсан, зогссон хоног	61
3.	Уурхайн жилд ажилласан хоног	304
4.	Ээлжийн тоо	2

“Биг могул коул энд энерги” ХХК-ийн “Хөөтийн хонхор”-2 нэртэй нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан-2025

5.	Ээлжийн үргэлжлэх хугацаа	12
6.	Жилд ажиллах цаг	7296

2025 оны уулын ажлын гүйцэтгэл

2025 оны 09-р сарын мэдээгээр ил уурхайн гүйцэтгэл хөрс хуулалт 173,568 м3 (69.39%), нүүрс олборлолт 38,010 тн (40.0%), уулын цул 200,718 м3 (63.1%) олборлосон гүйцэтгэлтэй байна.

Бүтэц орон тоо.

2025 оны 10-р сарын байдлаар 2 ээлжийн ИТА-д 14, засварын хэлтэст нийт 4, хүнд машин механизмын оператор 52 хүн буюу нийт 70 хүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс орон нутгийн 1 иргэн, гадаадын 0 иргэн ажиллаж байна.

2025 оны ус ашиглалтын мэдээ

Унд-ахуйн ус ашиглалт

2025 оны ус ашиглах дүгнэлтээр төслийн 2025 онд УАТ-ний Маягт-3-т үндэлэн тухайн жилд ажиллах хугацааг 365 хоног, нийт ажиллах хүний тоог 145 хүн (үүнээс үндсэн ажилтан-120, туслан гүйцэтгэгч-25), Унд ахуйн усны хэрэглээг БОНХАЖЯ-ны сайдын 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А/301 дугаар тушаалаар баталсан нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны нормын 12 дугаар хавсралтыг үндэслэж нэг хүний хоногт ашиглах усны хэмжээг 150 л-ээр тооцсон байна.

2025 онд унд-ахуйн хэрэглээнд ашиглах усны хэмжээ дүгнэлтээр 7938.75 м3 байна.

Хүснэгт 4- 2025 оны Ус ашиглуулах дүгнэлтээр тооцсон Унд-Ахуйд ашиглах усны хэмжээ

№	Хүний тоо	Нэг хүний хоногт ашиглах усны норм, л	Тухайн жилд нийт ажиллах хугацаа, хоног	Унд-ахуйн зориулалтаар ашиглах усны хэмжээ, м3
	145	150 л	365	7938.75

(Хүний тоо болон жилд ажиллах хугацааг 2025 оны Уулын ажлын төлөвлөгөөний Маягт-3-т тусгасан дүнд үндэслэсэн.)

2025 онд уурхай нь баяр наадам болон ажилчдын ээлжийн амралттай холбоотой нийт 61 хоног зогсож, 304 хоног үйл ажиллагаа явуулсан байна. Одоогоор уурхайд өөрийн компанийн 70 ажилтан, туслан гүйцэтгэгч компанийн 25 ажилтан буюу нийт 100 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Унд ахуйд ашиглаж буй гүний худаг (0.1 л/с ундаргатай)-т одоогоор тоолуур суурилуулаагүй байна.

Хүснэгт 5- 2025 онд уурхай ажилласан бодит хугацаанд үндэслэн тооцсон унд-ахуйн ус ашиглалт

№	Хүний тоо	Нэг хүний хоногт ашиглах усны норм, л	Тухайн жилд нийт ажиллах хугацаа, хоног	Унд-ахуйн зориулалтаар ашиглах усны хэмжээ, м3
	100	150 л	304	4560

Уурхайн бүс орчмын газрын гүний ус нь эрдэсжилт болон хатуулаг өндөртэй байдаг тул унд ахуйн хэрэглээнд зөөлрүүлэн ашигладаг.

Уурхайн гүний худагт 2023 оноос эхлэн гурван давхар шүүлтүүртэй ус цэвэршүүлэх төхөөрөмж ашиглаж байна.



Зам талбайн усалгаанд ашигласан усны хэмжээ.

Төслийн үйл ажиллагаанаас үүсэн тоосжилтыг дарахад 20 тн-ийн багтаамжтай усны машин ашигладаг. Усалгаа хийх нийт талбайн хэмжээ-12000.0 м² (Хөрсийг гадаад овоолгод тээвэрлэх замын урт 1,500.0 м, замын өргөн 8 м). Тоосжилт дарахад шаардлагатай усыг уурхайн шүүрлийн уснаас эргүүлэн ашиглах учир дүгнэлтээр усны төлбөрөөс 100 хувь хөнгөлсөн байна.

Тоосжилтоос үүдэн уурхай орчмын агаарын чанар муудахаас сэргийлэх болон хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах үүднээс зам, талбайн усалгааг өдөр бүр 3-4 удаа хийдэг. Нэг удаагийн усалгаанд 20 тн ус ашиглана.

Зам усалгааны ажлыг уурхайн бичиг хэргийн ажилтан өдөр бүрийн бүртгэлээр баталгаажуулдаг.

Хүснэгт 6- Зам талбайн усалгаанд ашигласан усны хэмжээ

Усалгаа хийх замын урт	Нэг удаагийн усалгаанд ашиглах усны хэмжээ, тн	Өдөрт усласан давтамж	Уурхайн нийт ажилласан хоног	Нийт ашигласан усны хэмжээ, тн
30 000 м ²	20	4	304	24,320

Зам усалгааны ажлын бүртгэлийн хуудас

Бүртгэлийн хуудаст дараах мэдээллийг багтаасан байна. Үүнд:

- Усалгааны ажлыг хариуцан гүйцэтгэсэн операторын нэр,
- Усалгааны ажил эхэлсэн болон дууссан цаг, нийт ажилсан цаг,
- Сул зогсолт болон ямар шалтгаанаар зам усалгааны ажил зогссон тухай тайлбар,
- Зам усалгааны давтамж буюу рейсийн тоо зэрэг мэдээллүүдийг бүртгэсэн.

“Биг могул коул энд энерги” ХХК-ийн “Хөөтийн хонхор”-2 нэртэй нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан-2025

Огноо	Ээлж	Оператор нэр	Хайсн ажил	Эхэлсэн мөч нэг	Дууссан мөч нэг	Ажил дэглэм мөч нэг	Бүтэл т нэг	Төсний ажилалтын хувь	Түшиг зарч	Сул зогсолт			Сул зогсолт, буцаа тайлбар			Засвартай зогсолт			Засвартай зогсолт, буцаа тайлбар
										Эхэлсэн нэг	Дууссан нэг	нэрүү	Эхэлсэн нэг	Дууссан нэг	нэрүү				
01.9-р сар	Өдөр																		
02.9-р сар	Өдөр	Лхагвалорж	Зам талбай уусалсан (4 удаа)	08:00	19:00	10	10	100											
03.9-р сар	Өдөр	Лхагвалорж	Зам талбай уусалсан (3 удаа)	08:00	19:00	10	10	100											
04.9-р сар	Өдөр	Лхагвалорж	Зам талбай уусалсан (5 удаа)	08:00	19:00	10	10	100											
05.9-р сар	Өдөр	Лхагвалорж						0											
06.9-р сар	Өдөр	Лхагвалорж	Зам талбай уусалсан (3 удаа)	14:00	19:00	5	10	50											
07.9-р сар	Өдөр	Лхагвалорж	Зам талбай уусалсан (5 удаа)	08:00	19:00	10	10	100											
07.9-р сар	Шөнө	Мягмардорж	Технологийн замд уусалгаа хийнэ	20:00	07:00	10	10	100											
08.9-р сар	Өдөр	Лхагвалорж	Зам талбай уусалсан (3 удаа)	08:00	19:00	10	10	100											
	Шөнө	Мөнхсүл	Зам талбай уусалсан (4 удаа)	20:00	07:00	6.9	10	69	23.30	02.40	03.10								
09.9-р сар	Өдөр	Лхагвалорж	Зам талбай уусалсан (5 удаа)	08:00	19:00	10	10	100											
	Шөнө	Мөнхсүл	Зам талбай уусалсан (5 удаа)	20:00	07:00	10	10	100											
0.9-р сар	Өдөр	Лхагвалорж	Зам талбай уусалсан (3 удаа)	08:00	19:00	10	10	100											
	Шөнө	Мөнхсүл	Зам талбай уусалсан (4 удаа)	20:00	07:00	10	10	100											
1.9-р сар	Өдөр	Мягмардорж	Технологийн замд уусалгаа хийнэ	08:00	19:00	10	10	100											
	Шөнө	Мөнхсүл	Зам талбай уусалсан	20:00	07:00	10	10	100											
2.9-р сар	Өдөр	Мягмардорж	Технологийн замд уусалгаа хийнэ	08:00	19:00	10	10	100											
	Шөнө	Мөнхсүл							20.00	07.00	10.00								
3.9-р сар	Өдөр	Мягмардорж							08.00	19.00	10.00								
4.9-р сар	Өдөр	Мягмардорж	Технологийн замд уусалгаа хийнэ	08:00	19:00	10	10	100											
5.9-р сар	Өдөр							0											
6.9-р сар	Өдөр							0											
7.9-р сар	Өдөр	Ганбаттар	Зам талбай уусалсан	08:00	19:00	10	10	100											
8.9-р сар	Өдөр	Ганбаттар	Зам талбай уусалсан	08:00	19:00	10	10	100											
9.9-р сар	Өдөр	Ганбаттар	Зам талбай уусалсан	08:00	19:00	10	10	100											
10.9-р сар	Өдөр	Ганбаттар	Зам талбай уусалсан	08:00	19:00	10	10	100											
11.9-р сар	Өдөр	Ганбаттар	Зам талбай 3 удаа уусалсан	08:00	19:00	10	10	100											
12.9-р сар	Шөнө	Ганбаттар	Зам талбай 4 удаа уусалсан	08:00	19:00	10	10	100											
13.9-р сар	Өдөр	Ганбаттар	Зам талбай 5 удаа уусалсан	08:00	19:00	10	10	100											
14.9-р сар	Шөнө	Ганбаттар	Зам талбай уусалсан	08:00	19:00	10	10	100											
15.9-р сар	Өдөр	Ганбаттар	Зам талбай уусалсан	08:00	19:00	10	10	100											
16.9-р сар	Шөнө	Ганбаттар	Зам талбай уусалсан	08:00	19:00	10	10	100											
17.9-р сар	Өдөр	Ганбаттар	Зам талбай уусалсан	08:00	19:00	10	10	100											



Зураг 3- Зам усалгааны ажлыг баталгаажуулсан фото зураг

Ногоон байгууламжын усалгаа

“Тэр бум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2025 оны 05-р сард уурхайн кемпийн гадна нийт 400 ширхэг шар хуайс, 200 ширхэг хайлас модны 3-4 настай суулгац шуудуулан тарьсан. Ногоон байгууламжын усалгаанд ашиглах усыг уурхайн шүүрлийн уснаас хангав.

Ногоон байгууламжийн усалгаанд ашигласан усны хэмжээг баримтжуулсан бичиг баримт байхгүй тул усны хэрэглээг Монгол улсын Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын А/301 дугаартай тушаалын хавсралтаар баталсан Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны нормд заасан 1 ш суулгац услах усны норм /40 л/-оор тооцлоо.

“Биг могул коул энд энерги” ХХК-ийн “Хөөтийн хонхор”-2 нэртэй нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан-2025

Хүснэгт 6.Ногоон байгууламжын усалгаанд ашигласан усны хэрэглээ

Суулгацын тоо, ш	1 ш суулгац усах норм, л	Усалгаа хийсэн хоногийн тоо	Нийт ашиглах усны хэмжээ, м3
600	40	32	768 м3



Зураг 4. Ногоон байгууламжын усалгаа


2025 онд уурхайн ухлагын явцад шүүрэн орж ирэх усны хэмжээ.

2025 оны Ус ашиглуулах дүгнэлтээр тооцсон дүнгээр уурхайн ухлагын явцад карьерт шүүрэн орж ирэх усны хэмжээг 31,937.50 м3 байхаар тооцсон байна.

Хүснэгт 7- Уурхайн карьерт шүүрэн орж ирэх усны хэмжээ, м3 (Дүгнэлтээр)

Ажлын нэр	Тоо Хэмжээ	Хэмжих нэгж	Усны хэрэглээ, м3 (Норм)	Гүйцэтгэх давтамж	Хэмжих нэгж	Нийт ашиглах усны хэмжээ, м3	Хөнгөлөх усны хэмжээ м3	Төлбөр тооцох усны хэмжээ м3
Уурхайн ухлагад шүүрэн орж ирэх усны хэмжээ	87.5	м3	1.0	365.0	Хоног	31,937.50	0.00	31,937.50

Хөөтийн чулуун нүүрсний ордын Хөөтийн хонхор-2 уурхайн гүн 2025 оны 12-р сарын байдлаар 35,0 м байна. Ус шүүрүүлэх ажлыг дренажаар дамжуулан зумфпын аргаар гүйцэтгэж байна. Зумфпэнд хуримтлагдсан усыг 6sp30-12 загварын насосны бүтээмж: $Q = 28-30-36$ м3/цаг, даралтын хэмжээ: 100-94-74 м байна. Насосоор хоногт 85.95 м3 усыг шүүрүүлэн зайлуулж байна. Зумфпын урт – 5,0, өргөн – 4,0, гүн – 3,0.



Усны газрын 2024 оны 02-р сарын 20-ний өдрийн 47 дугаар Ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлтээр өгсөн зөвлөмжийн дагуу 2025 оны 01-р сард ордын “Гидрогеологийн нарийвчилсан судалгаа”-г “Орд-Ус” ХХК-ийн мэргэжилтнээр хийлгэсэн. Уг судалгаагаар уурхайд уурхайн хана, мөргөцгөөс орж ирж байгаа усны хэмжээ 1.01 л/сек гэж тооцсон байна.

Уурхай нь хүйтний эрчим ихсэх үед зумпэнд хуримтлагдсан ус болон ус соруулж буй насос хөлдөснөөр шүүрлийн ус соруулах ажлыг түр зогсоодог.

2025 онд 01-р сараас 04-р сарын 24-ний өдөр хүртэл уурхай нь шүүрлийн ус соруулах ажил гүйцэтгээгүй бөгөөд шүүрлийн ус соруулах ажлыг эхлэх үед Баянжаргалан сумын Захиргаанд хүсэлт хүргүүлж сумаас томилогдсон ажлын комиссоос хяналт шалгалт хийж баталгаажуулсны дараа тухайн оны ус соруулах ажлыг эхэлсэн, мөн 2025 оны 07-р сарын 01-ний өдрөөс 08-р сарын 30 хүртэл уурхай түр зогссон.

Иймд тухайн онд нийт 175 хоног шүүрлийн ус соруулах ажил гүйцэтгээгүй ба 2025 онд нийт 190 хоног шүүрлийн ус соруулсан байна.

Хүснэгт 8- Шүүрлийн ус соруулсан бодит хугацаанд үндэслэн тооцоолсон шүүрлийн усны хэмжээ

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Утга
	Тухайн онд уурхай зогссон хугацаа	Хоног	61
	Тухайн жилд уурхай зогсолтгүй ажилласан хугацаа	Хоног	304
	Шүүрлийн ус соруулах ажил зогссон хугацаа	Хоног	114
	Нийт шүүрлийн ус соруулсан хугацаа	Хоног	190
	Карьер орж ирэх шүүрлийн усны хэмжээ	м3/хоног	87.5
	Нийт соруулсан шүүрлийн усны хэмжээ	м3	16,625



Зураг 5. Ус хуримтлуулах зумп 2025 оны 04-р сарын байдлаар

ГУРАВ. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Манай Дундговь аймгийн Баянжаргалан сумын Энгэр-Ус багийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлж буй “Хөөтийн хонхор-2 нэртэй нүүрсний ордыг ил аргаар ашиглах төсөл”-ийн 2025 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг (БОМТ) “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам”-аар 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр батлуулсан.

2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан төсөв:

2025 оны “Байгаль орчны менежмент”-ийн төлөвлөгөөнд нийт 44,083.00 төгрөгийн зардал төсөвлөж Байгаль орчны нөхөн сэргээлтийн барьцаа төлбөр буюу тухайн жилийн БОМТ-ийн зардлын 50 хувь болох 22,041,500.00 төгрөгийн төлбөрийг төрийн сангийн дандсан тушаасан байна.

БОМТ-ний биелэлтийн хэсэг нь дараах хэсгээс бүрдэнэ. Үүнд:

1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө
2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө
3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө
4. Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох төлөвлөгөө
5. Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө
6. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө
7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө
8. Орчны хяналт шинжилгээний хэсэг
9. Биелэлтийн тайлангын хэрэгжилтийг тайлагнах гэсэн нийт 9 хэсгээс бүрдэнэ.

3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 9- Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах төлөвлөгөө

№	Төлөвлөсөн ажил	Биелэлт	Тайлбар
1.	Уурхайн карьер, овоолго, зам, талбайн усалгааг 2025 оны 04-р сараас 10-р сар хүртэл бороо, цастай өдрөөс бусад өдрүүдэд компанийн өөрийн эзэмшлийн 20 тн-ийн багтаамжтай зам усалгааны машинаар хийнэ.	Уурхайн дараах хэсгүүдэд нийт 12,000 м ³ талбайд усалгааг тогтмол хийж ажиллав. Үүнд: - Уурхайн карьер дотор, - Уурхайн дотоод тээврийн зам, - Нүүрс ачиж буулгах хэсэг Зам усалгааны ажилд 20 тн-ийн багтаамжтай усны машин ашигладаг. 2025 онд зам усалгааны ажилд нийт 23,680 тн ус ашигласан.	Усалгааны машины замын хуудас болон зам усалгааны зураг хавсаргав.
2.	Агаарын чанарыг хянах дотоод хяналтын багаж хэрэгсэлтэй болох (БО-ны АУДИТ-ын тайланд тусгасан зөвлөмж)	2025 оны 10-р сарын 09-ний өдрөөс эхлэн А25D маркийн агаарын нарийн ширхэгт тоосонцор (PM 2.5) болон чийгшил хэмжигч багаж ашиглан агаарын чанарын хяналтын цэгүүдэд өдөрт гурван удаа тогтмол цагт хэмжилт хийсэн. Хэмжилсэн үзүүлэлтийг “Агаарын	Агаарын чанарын хэмжилтийн утгад хийсэн дата анализ болон хэмжилтийн явцын зургаар баталгаажуулав.

		чанарын стандарт. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4585:2016 стандартад заасан 24 цагийн дундаж агууламжтай харьцуулан хяналт явуулав.	
3.	Уурхайн дотоод болон гадаад тээврийн зам, уурхайн шалган нэвтрүүлэхээс гараад зүүн урагш 400 м зайд байх эвдрэл үүсэх эрсдэлтэй хэсэгт тогтмол хяналт тавьж зам засаж сайжруулж байх	2025 онд өөрийн уурхайн шалган нэвтрүүлэхээс гараад зэргэлдээ үйл ажиллагаа явуулдаг “Уулс мандал” ХХК-ийн “Хар тэвш” нүүрсний уурхай хүртэлх нийт 2.4 км замын засаж сайжруулах ажлыг хийсэн.	Зам засварын ажлын зургаар баталгаажуулав.
4.	Уурхайн карьер, овоолгод ажиллаж байгаа ачиж буулгах, тээвэрлэх машин техникийн кабин доторх агаарыг цэвэршүүлэх төхөөрөмж хэрэгслийн бүрэн бүтэн байдал, хаалга цонхны чигжээс, хамгаалалтын үзлэгийг тогтмол хийж, зөрчил илэрсэн тохиолдолд шуурхай арга хэмжээ авч байх	Уурхайд ашиглаж байгаа техникүүдийн үзлэг оношилгоог тогтмол хийдэг бөгөөд өглөө оройны ээлжийн операторууд ээлж солилцох үедээ техникийн агаар шүүгч, хаалга, цонхны чигжээс болон бусад эд ангийн бүрэн бүтэн байдал, хэвийн ажиллагааг шалган бүртгэл хөтөлдөг.	Хяналт шалгалт хийсэн ажлын зургаар баталгаажуулав.
5.	Уурхайн дотоод тээврийн зам дагуу шаардлагатай хэсгүүдэд хурдны хязгаарын тэмдэг тэмдэглэгээ нэмж байршуулах	Уурхайд 2 ээлжийн хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтнүүд дотоод тээврийн замын хурдны хязгаарын тэмдэг байршуулах шаардлагатай хэсгүүдийг тэмдэгжүүлж тэдгээрийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажилласан 2025 онд уурхайн дотоод тээврийн зам дагуу шинээр 3 цэгт хурдны хязгаарын тэмдэгийг нэмж байршуулсан.	Хурдны хязгаар тогтоосон тэмдэг байршуулсан фото зургаар баталгаажуулав.
6.	Тоосноос эрүүл мэндээ хамгаалах нэг бүрийн хэрэгсэл, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах, тэдэнд сургалт, суртачилгаа явуулах	Уурхайн ХАБ-ын мэргэжилтэн нь карьерт буюу тоосжилт ихээр үүсэх хэсэгт ажиллаж буй ажилчдыг тоосноос эрүүл мэндээ хамгаалах нэг бүрийн хэрэгслээр тогтмол хангаж ажилладаг. Хүйтний улирал эхлэх үед буюу 2025 оны 09-р сараас эхлэн ажилчдын хоол хүнсэнд нэмэлтээр халуун аарц, чацаргана зэрэг дархлаа дэмжих бүтээгдэхүүнээр	Сургалт зохион байгуулсан ажлын фото зураг, сургалтанд хамрагдсан ажилчдын гарын үсэг, Хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангасан ажлын фото зургийг

		хангаж эхлэсэн. Ээлж бүрт уурхайн ХАБЭББО-ны хэлтсээс эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал, байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр сургалт зохион байгуулж ажилласан. 2025 онд Байгаль орчны чиглэлээр нийт 4 сэдвийн хүрээнд сургалт орсон. Мөн Баянжаргалан сумын захиргаатай хамтран 2025 оны 11-р сарын 1-ний өдөр уурхайн 2 ээлжийн нийт ажилчдыг хөдөлмөрийн харилцаа, нийгмийн халамж үйлчилгээ, газрын цахим систем, байгаль хамгаалах чиглэлээр сургалтанд хамруулсан.	хавсаргав.
7.	Нүүрс ачсан бүх тээврийн хэрэгслийн ачааны хэсгийг бүтээлэгтэй байлгах тал дээр анхаарч, шаардлага тавьж ажиллах	Нүүрс ачсан тээврийн хэрэгслийн ачааны хэсгийг бүтээлэгтэй байлгах тал дээр уурхайн харуул хамгаалалтын нэгж тогтмол хяналт тавьж ажиллаж байна.	Хяналтын ажлыг баримтжуулсан фото зураг хавсаргав.
8.	Төслийн үйл ажиллагааны явцад дагаж мөрдөх тоосжилтыг хянах бууруулах тухай дотоод журмыг Монгол улсын хууль, стандартад нийцүүлэн, уурхайн үйл ажиллагаа, орчны төлөв байдалтай уялдуулж боловсруулах	Уурхайн орчинд тоосжилтыг бууруулах, хяналт тавьж ажиллахтай холбоотой дотоод журмыг боловсруулан мөрдөж ажиллаж байна.	Журмын батлагдсан нүүрийг хавсралтаар оруулав.
Бүлгийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлын: 8 Хэрэгжүүлсэн ажлын тоо: 8			

Зам усалгааны ажлын бүртгэлийн хуудас

Бүртгэлийн хуудаст дараах мэдээллийг багтаасан байна. Үүнд:

- Усалгааны ажлыг хариуцан гүйцэтгэсэн операторын нэр,
- Усалгааны ажил эхэлсэн болон дууссан цаг, нийт ажилсан цаг,
- Сул зогсолт болон ямар шалтгаанаар зам усалгааны ажил зогссон тухай тайлбар,
- Зам усалгааны давтамж буюу рейсийн тоо зэрэг мэдээллүүдийг бүртгэсэн.

“Биг могул коул энд энерги” ХХК-ийн “Хөөтийн хонхор”-2 нэртэй нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан-2025

Огноо	Ээлж	Оператор нэр	Хийсэн ажил	Эхэлсэн мөчлөг	Дууссан мөчлөг	Ажилласан мөчлөг	Бүтээгдсэн хэмжээ	Техник ангилалын хувь	Түний зарч	Сул зогсолт			Сул зогсолт, бүтэл тайлбар	Засвартай зогсолт			Засвартай зогсолт, бүтэл тайлбар
										Эхэлсэн	Дууссан	зөрүү		Эхэлсэн	Дууссан	зөрүү	
01.9-р сар	Озёр																
02.9-р сар	Озёр	Лхагвалорж	Зам талбай усалсан (4 удаа)	08:00	19:00	10	10	100									
03.9-р сар	Озёр	Лхагвалорж	Зам талбай усалсан (3 удаа)	08:00	19:00	10	10	100					Тог тасарсан.				
04.9-р сар	Озёр	Лхагвалорж	Зам талбай усалсан (5 удаа)	08:00	19:00	10	10	100									
05.9-р сар	Озёр	Лхагвалорж					10	0						08:00	19:00	10:00	Засварт орсон.
06.9-р сар	Озёр	Лхагвалорж	Зам талбай усалсан (3 удаа)	14:00	19:00	5	10	50						08:00	13:00	05:00	Засварт орсон.
07.9-р сар	Озёр	Лхагвалорж	Зам талбай усалсан (5 удаа)	08:00	19:00	10	10	100									
08.9-р сар	Шань	Мягмарзорж	Технологийн замд усалгаа хийв	20:00	07:00	10	10	100									
09.9-р сар	Озёр	Лхагвалорж	Зам талбай усалсан (5 удаа)	08:00	19:00	10	10	100									
10.9-р сар	Шань	Монхсүл	Зам талбай усалсан (4 удаа)	20:00	07:00	8.9	10	69		23:30	02:40	03:10	Агаарын савтал шороон шуурга болсон.				
11.9-р сар	Озёр	Лхагвалорж	Зам талбай усалсан (5 удаа)	08:00	19:00	10	10	100									
12.9-р сар	Шань	Монхсүл	Зам талбай усалсан (5 удаа)	20:00	07:00	10	10	100									
01.9-р сар	Озёр	Лхагвалорж	Зам талбай усалсан (3 удаа)	08:00	19:00	10	10	100									
02.9-р сар	Озёр	Мягмарзорж	Зам талбай усалсан (4 удаа)	20:00	07:00	10	10	100									
03.9-р сар	Озёр	Монхсүл	Зам талбай усалсан (4 удаа)	20:00	07:00	10	10	100									
04.9-р сар	Озёр	Мягмарзорж	Технологийн замд усалгаа хийв	08:00	19:00	10	10	100									
05.9-р сар	Озёр	Монхсүл	Зам талбай усалсан	20:00	07:00	10	10	100									
06.9-р сар	Озёр	Мягмарзорж	Технологийн замд усалгаа хийв	08:00	19:00	10	10	100									
07.9-р сар	Озёр	Монхсүл					10	100		20:00	07:00	10:00	Агаарын савтал бороо орж зогссон.				
08.9-р сар	Озёр	Мягмарзорж	Технологийн замд усалгаа хийв	08:00	19:00	10	10	100		08:00	19:00	10:00	Бороо орж зам талбайг усалгаа шаардлагагүй тул нөөцлөх зогссон.				
09.9-р сар	Озёр	Мягмарзорж					10	0									
10.9-р сар	Озёр	Мягмарзорж					10	0									
11.9-р сар	Озёр	Ганбаттар	Зам талбай усалсан	08:00	19:00	10	10	100									
12.9-р сар	Озёр	Ганбаттар	Зам талбай усалсан	08:00	19:00	10	10	100									
13.9-р сар	Озёр	Ганбаттар	Зам талбай усалсан	08:00	19:00	10	10	100									
14.9-р сар	Озёр	Ганбаттар	Зам талбай усалсан	08:00	19:00	10	10	100									
15.9-р сар	Озёр	Ганбаттар	Зам талбай усалсан	08:00	19:00	10	10	100									
16.9-р сар	Озёр	Ганбаттар	Зам талбай усалсан	08:00	19:00	10	10	100									
17.9-р сар	Озёр	Ганбаттар	Зам талбай усалсан	08:00	19:00	10	10	100									



Зураг 6. Замын усалгааны бүртгэлийн хуудас, зам усалгааны ажлын зураг

2025 оны 03-р сарын 22-ний өдөр орон нутгаас ирсэн саналын дагуу Баянжаргалан сумын урдуур өнгөрөх нүүрс тээврийн замын усалгаа хийсэн.



Орчны тоосжилтыг багасгах зорилгоор хэрэгжүүлсэн агаарын тоосжилтын хэмжилт, хяналтын (5 хоногийн мэдээ) ажлын үр дүн.



Зураг 7. Агаарын бохирдлын хяналтын цэгийн байршил
2025.11.04-2025.11.08-ний хоорондох хэмжилтийн утгыг Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага 4546:2025 стандартад заасан РМ 2.5 тоосонцрын 24 цагийн дунданж утгатай харьцуулж график 1-т харуулав.




График 1. Агаарын тоосжилтын хэмжилтийн мэдээ (5 хоногийн мэдээ)

Хяналтын цэг:

- A1- засварын талбай
- A2- Карьерийн дээд хэсэг
- A3- нүүрс ачих, буулгах талбай
- A4- Карьерийн дотор
- A5- Кемпийн гадна талбай



Зураг 8. Агаарын тоосжилтын хэмжилтийн ажлын зураг

2025 онд гүйцэтгэсэн зам засварын ажил.



Зураг 9. Зам засварын ажлын зураг (замын урт 2.4 км)

“Биг могул коул энд энерги” ХХК-ийн “Хөөтийн хонхор”-2 нэртэй нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан-2025

Уурхайн карьер, овоолгод ажиллаж байгаа ачиж буулгах, тээвэрлэх машин техникийн кабин доторх агаарыг цэвэршүүлэх төхөөрөмж хэрэгслийн бүрэн бүтэн байдал, хаалга цонхны чигжээс, хамгаалалтын үзлэгийг тогтмол хийх ажлын хүрээнд хэрэгжүүлсэн ажил.

№	Эд анги	хэвийн + гэмтэлтэй -	тайлбар
1	Маяак	+	
2	Галын хор	+	
3	Их гэрэл	+	
4	Тормозны гэрэл	+	
5	Ухрахын гэрэл	+	
6	Хаалганы дохио гэрэл	+	3X гэмтэлтэй, солих
7	Салхины шил	+	
8	Толь	+	
9	Тормозны ажиллагаа	+	
10	Рүлийн ажиллагаа	+	
11	Моторын ажиллагаа	+	
12	Хроп	+	
13	Төхөөрөмжийн ажиллагаа/подъем/	+	
14	Тосолгоо	+	
15	Цэвэрлэгээ үйлчилгээ	+	
16	Дугуй	+	
17	Дугуйн ивээс	+	
18	Гар тормозны ажиллагаа	+	
19	Агаар шүүгч	+	
20	Кабины битүүмж	+	

Зураг 10. Тээврийн хэрэгсэл хүлээлцэх акт бүртгэсэн байдал

Тээврийн хэрэгслийн хаалга, цонхны чигжээс, агаар шүүгчийн бүрэн бүтэн байдал, галын хор, эмнэлгийн анхан тусламжын хайрцаг





Зураг 11. Техникийн үзлэг шалгалтын ажлын зураг

Хурдны хязгаар тогтоосон тэмдэг байришуулсан ажил.





Зураг 12. Хурдны хязгаар тогтоосон тэмдэг нэмж байршуулсан ажлын зураг

Нүүрс ачсан тээврийн хэрэгслийн ачааны хэсэг бүтээлэгтэй эсэхэд хяналт тавьсан ажлыг баримтжуулсан фото зураг






Зураг 13.

2025 онд зохион байгуулсан сургалтын ажлын мэдээлэл.


2025 оны 09-р сарын 11-ний өдөр 1-р ээлжийн нийт 39 ажилчдад “Хог хаягдлын менежмент” сэдвээр сургалт зохион байгуулсан.





Зураг 14. “Хог хаягдлын менежмент” сэдвээр сургалт зохион байгуулсан ажлын зураг

2025.09.11-нд уурхайн эмч 1-р ээлжийн нийт 39 ажилчдад Эрүүл ахуйн, эрүүл мэндийн боловсрол олгох сургалт зохион байгуулсан.



2025 оны 11-р сарын 01-ний өдөр Баянжаргалан сумын Засаг Даргын Тамгын газартай хамтран зохион байгуулсан сургалтын ажлын зураг



Ажилчдыг дараах хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр ханган ажиллаж байна. Үүнд: Ажлын иж бүрэн хувцас, каск, тоосноос хамгаалах давхар шүүлтүүртэй маск, нүд хамгаалах хэрэгсэл



Зураг 15. Уурхайд ашиглаж буй тоосноос хамгаалах маск

Хүснэгт 10- Хөрсөн бүрхэвч, гадаргын хэлбэрт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө

Д/д	Төлөвлөсөн ажил	Биелэлт	Тайлбар
1.	Шинээр эвдрэлд өртөх талбайн шимт хөрсийг 20-25 см зузаантайгаар хуулж овоолгод хадгалах	2025 онд уулын ажлын хүрээнд шимт хөрс хуулалтын ажил хийгдээгүй. Уурхайн олборлолтын явцад өмнө хуулсан шимт хөрсийг овоолго үүсгэн хадгаладаг байгаа бөгөөд 2025 онд хуучин овоолго үүсгэн хадгалсан шимт хөрсний овоолгыг түрж хэлбэршүүлэн, тэмдэгжүүлсэн.	Шимт хөрсний овоолгыг тэмдэгжүүлсэн ажлын зураг хавсаргав.
2.	ШТМ-ыг стандартын шаардлага хангасан саванд хадгалах, асгарч алдагдахаас сэргийлэх, байгаль орчныг бохирдуулахаас хамгаалах, бохирлогдсон тохиолдолд саармагжуулах, аюулгүй болгох арга хэмжээ авах	2025 онд тус чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн байгууллага болох “Нано дизель” ХХК-тай гэрээ байгуулан хуучин ШТС-ын түлш хадгалах савыг газарт булж, ШТС-ын орлого авах хэсгийг хашаалан, тэмдэгжүүлэн стандартын дагуу тохижуулсан. Мөн засварын талбайд шатах тослох материал асгарсан тохиолдолд асгарсан тосыг элс ашиглан шингээн авч, бохирдосон хэсгийг цэвэрлэх арга хэмжээ авч ажиллаж байна.	ШТС-ын одоогийн фото зураг болон далд ажлын актууд хавсаргав.
3.	Засварын талбайг ШТМ-аар хөрс бохирохоос сэргийлэн хатуу хучилттай болгох, мөн засвар хийх талбай техник зогсох хэсэг, засвараас гарсан хог хаягдлыг байршуулах хэсгийг тэмдэгжүүлэх	2025 онд шинээр засвар үйлчилгээний төвийг ашиглалтад оруулсан. Хуучин засварын талбайд тос маслоны сав баглаа боодлын хаягдал хадгалах агуулахыг тохижуулж тэмдэгжүүлсэн, засвараас гарсан төмрийн хаягдлыг тусдаа талбайд байрлуулан хадгалж байна.	Шинээр ашиглалтад оруулсан засвар үйлчилгээний байр, шинээр сав баглаа боодол хадгалах агуулахын зураг хавсаргав.
4.	Хөрсний бохирдол үүсгэхээс сэргийлэх болон олон салаа зам гаргахгүй байх талаар жолооч операторуудад сургалт явуулах	2025 оны 10-р сарын 06-ний өдөр 2-р ээлжийн нийт 37 ажилтанд хөрсний бохирдол сэдвээр сургалт орсон.	Сургалт зохион байгуулсан ажлын зураг хавсаргав.

5.	Хөрс бохирдуулагч нүхэн жорлонг буулгах	2025 онд кемпийн гадна байсан нүхэн жорлонг ашиглалтаас гаргаж 25 тн-ийн бохир хадгалах танктай ариун цэврийн байгууламжыг ашиглалтад оруулж “Дундговь-Ус” ХХК-тай бохир ус соруулах гэрээ байгуулан ажиллаж байна.	Дундговь-Ус ХХК-тай байгуулсан бохир ус соруулах гэрээ болон, ус соруулах ажил гүйцэтгэсэн ажлын акт хавсаргав.
Бүлгийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлын: 5 Хэрэгжүүлсэн ажлын тоо: 5			

Шимт хөрсний овоолгыг тэмдэгжүүлэв.



Зураг 16. Шимт хөрсний овоолгыг хэлбэршүүлж тэмдэгжүүлсэн ажлын зураг

ШТС-ыг стандартын шаардлагад нийцсэн байдлаар тохижуулав.

Өмнө



Дараа






Зураг 17. ШТС-ын нөөцлүүр савыг газарт булж стандартын дагуу тохижуулсан ажлын зураг (далд ажлын актуудыг хасралт маериалд хавсаргав.)

2025 онд шинээр ашиглалтад оруулсан засвар үйлчилгээний төв.



Тос маслоны сав, баглаа боодол хадгалах хэсэг



Ашигласан тосны хаягдал хадгалах хэсэг



Зураг 18. Засвараас гарсан хог хаягдал хадгалах хэсгийг тэмдэгжүүлсэн ажлын зураг

*Хөрсний бохирдол сэдвээр зохион байгуулсан сургалтын ажлын зураг.
Тус сургалтад уурхайн 2-р ээлжийн нийт 27 хүн хамрагдав.*



Зураг 19. Хөрсний бохирдол сэдвээр зохион байгуулсан сургалтын ажлын зураг

Хүснэгт 11- Гадаргын болон газрын доорх усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах төлөвлөгөө

Д/д	Төлөвлөсөн ажил	Биелэлт	Тайлбар
1.	Ил уурхайн дэргэд газрын доорх усны түвшин, чанарын өөрчлөлтийг хянах мониторингийн цооногт тогтмол хэмжилт дээжлэлт хийж байх	Уурхайн карьерын дэргэд хайгуулын ажлын үед гаргасан Н-2, Н-2А цооногуудад усны түвшний хэмжилт хийхээр төлөвлөсөн ч хэмжилтийн багажид эвдрэл үүсэнтэй холбоотой тогтмол хэмжилт хийх боломжгүй болсон.	-

“Биг могул коул энд энерги” ХХК-ийн “Хөөтийн хонхор”-2 нэртэй нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан-2025

2.	Шүүрлийн усыг татан зайлуулж хөв цөөрөм байгуулах талаар усны мэргэжлийн байгууллага эсвэл усны нарийн мэргэжилтэнтэй хамтран суурь судалгааны ажлыг хийж, үр дүнг орон нутагт танилцуулна.	Тус ажилтай холбоотой уурхайн үйл ажиллагаа явуулж буй бүс нь хөв цөөрөм байгуулах боломжтой байршилд оршдог эсэх талаар дүгнэлт авахаар Харьяа сав газрын захиргаанд хүсэлт хүргүүлсэн байна.	-
3.	Төслийн хэрэгцээнд ашиглаж буй усны зарцуулалтыг хэмжих зорилгоор ашиглаж буй усны эх үүсвэрт мэргэжлийн байгууллагаар баталгаажуулсан тоолуур тавих	2024 онд уурхайн унд ахуйд ашиглаж буй гүний худгийг тоолууржуулсан. 2025 онд шүүрлийн ус соруулж буй хэсэгт тоолуур тавиулахаар мэргэжлийн байгууллагад хүсэлт хүргүүлсэн бөгөөд тоолуур суурилуулахад шаардлагатай бэлтгэл ажлыг хангасан байна.	Тоолуур суурилуулахтай холбоотой хийгдсэн бэлтгэл ажлын зургийг хавсаргав.
4.	Шүүрлийн усыг шаардлага хангасан хаягдлын сан байгуулан хуримтлуулах, шинжилгээнд хамруулах	2025 оны 10-р сард шүүрлийн ус хуримтлуулж буй зуумпнаас дээж авч “Инженер геодези” ХХК-ийн Хөрс судлалын лабораториор “4943:2015 Хаягдал усны стандарт”-ын дагуу шинжилгээ хийлгэсэн. Шинжилсэн үзүүлэлтүүд стандартад заасан хэмжээнээс даваагүй байна.	ОХШХ-т дэлгэрэнгүй тусгав.
5.	Нийтийн ариун цэврийн байгууламжийг MNS5924:2015 стандартад нийцүүлэх	2025 онд стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжыг ашиглалтанд оруулсан.	Ариун цэврийн байгууламжын зураг хавсаргав.
Бүлгийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажил: 5 Хэрэгжүүлсэн ажлын тоо: 2 Хэрэгжүүлж байгаа ажлын тоо: 2 Хойшлуулсан ажлын тоо: 1			

2025 оны 10 сарын байдлаар шүүрлийн ус соруулж буй хэсэгт тоолуур суурилуулахаар “Дундговь-Ус” ХХК-ийн мэргэжилтнүүдтэй холбогдон мэргэжилтнээс тавьсан шаардлагын дагуу тоолуур хөлдөхөөс сэргийлж бэлтгэл ажлыг хангасан.

Энэ хүрээнд тоолуур суурилуулах зориулалтын байгууламжийг бэлтгэх, мөн халаалт болон гэрэлтүүлгийн ажлыг хийж гүйцэтгэлээ.



Зураг 20. Тоолуур суурилуулсны дараа хөлдөхөөс сэргийлж байгууламж бэлдэн, тог цахилгааныг шийдсэн, тен байрлуулсан байдал.

2025 онд уурхайн кемпийн гаднах нүхэн жорлонг ашиглалтаас гаргаж шинээр 25 тн бохир хадгалах багтаамжтай ариун цэврийн байгууламжыг ашиглалтанд оруулсан. Үүнтэй холбоотой ахуйн бохир ус соруулах гэрээг Дундговь аймагт үйл ажиллагаа явуулдаг “Дундговь-Ус” ХХК-тай байгуулан хамтран ажиллаж байна. Тус онд 2 удаагийн соруулалтаар нийт 12 тн бохир усыг гэрээний дагуу мэргэжлийн байгууллагаар соруулсан.



Зураг 1. Бохир хуримтлуулах 25 тн багтаамжтай танк суурилуулсан байдал.


Хүснэгт 12- Ургамал ба амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах төлөвлөгөө

Д/д	Төлөвлөсөн ажил	Биелэлт	Тайлбар
1.	Барилга байгууламж, ажилчдын хотхоны гадна талбайд ногоон байгууламж бий болгох зорилгоор мод сөөг тарьж ургуулах	2025 онд кемпийн гадна бүс нутгийн уур амьсгалын онцлог, хөрсний хэв шинж, хуурайшилт өндөртэй зэрэг нөхцөлийг харгалзан үзэж орчиндоо дасан зохицон ургах чадвар сайтай, тэсвэртэй дараах гурван төрлийн модыг сонгосон бөгөөд 2-3 настай суулгацыг шуудуулан тарьсан. — Шар хуайс- 400 ш, — Хайлаас-100 ш , — Буйлс-100 ш	Нөхөн сэргээлт ногоон байгууламжын төлөвлөгөөнд дэлгэрэнгүй тусгав.
2.	Зэрлэг амьтдын амьдардаг гол тархац нутаг, уст цэг орчимд хужир шүү, тэжээл тавих, өвөл хаврын хуурайшилт ихтэй үед усан хангамжийг сайжруулах зэргээр биотехникийн арга хэмжээг орон нутгийн захиргаатай хамтран зохион байгуулах	Тус ажлыг 2023 оноос хойш жил бүр хэрэгжүүлэн биелэлтийг хангаж ажилласан бөгөөд 2025 оны 11-р сард сумын байгаль хамгаалагчид 100 боодол өвс хүлээлгэн өгсөн.	Фото зураг хавсаргав.
3.	Уурхайн карьер руу мал орохоос сэргийлж тогтмол хяналт тавьж ажиллах	Уурхайд харуул хамгаалалтын нэгж тогтмол хяналт шалгалт хийж, уурхайн хамгаалалтын бүсээр нэвтэрсэн мал, амьтныг илрүүлэн талбайгаас гаргах арга хэмжээг авч ажилладаг.	Ажлын зураг хавсаргав.
4.	Биологийн төрөл зүйлийн ач холбогдол, хамгаалах чиглэлээр нийт ажилчдад сургалт явуулах	2025 оны 04-р сарын 29-ний өдөр уурхайн 2-р ээлжийн нийт 27 ажилчдыг хамруулан “Биологийн төрөл зүйлийн ач холбогдол” чиглэлээр сургалт зохион байгуулсан.	Сургалтанд хамрагдсан ажилчдын гарын үсэг хавсаргав.
5.	Амьтны талаар нарийвчилсан судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	“Мэнд шүтээн” ХХК-ийн мэргэжилтнүүдтэй хамтран тухайн бүсийн амьтдын талаар судалгааны ажлыг	Судалгааны ажлын үр дүнг дэлгэрэнгүй тусгав.

		хэрэгжүүлсэн.	
	Бүлгийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажил: 5 Хэрэгжүүлсэн ажлын тоо: 5		




Зураг 21. Зэрлэг амьтдад өвс, тэжээл тавьж өгөх арга хэмжээг хэрэгжүүлсэн ажлын зураг





Зураг 22. Уурхайн зогоон руу орсон малыг хөөж гаргасан ажлын хавсаргав.
(2025.10.02-ний өдрийн харуулын хяналт шалгалтын үед илэрсэн зөрчил)



Зураг 23. Сургалтанд хамрагдсан ажилчдын нэрс

Бүс нутгийн амьтны аймгийн судалгааны ажлын үр дүн

Төсөл хэрэгжих талбай орчмын амьтны аймгийн судалгааг 2024 онд тус төслийн БОННУ-ний нэмэлт тодотголын ажлын үед хийгдсэн судалгааны материалыг үндэслэв.

“Хөөтийн хонхор-2” нүүрсний ордын бүс нутаг нь Монгол орны амьтны аймгийн газарзүйн мужлалаар Монгол-Төвдийн муж, Монгол дагуурын хээрийн дэд муж, Монгол дагуурын хээрийн тойргийн урд зах Дорноговийн хээрийн тойргийн хойд захад хамаарна.

Монгол дагуурын хээрийн тойрогт жижиг хөхтнөөс үлийн цагаан оготно, дагуур огдой, дагуурын зурам, монгол чичүүл, туруутнаас аргаль хонь, янгир ямаа, цагаан зээр, мах идэшт амьтдаас хотны үен, өмхий хүрнэ, хярс үнэг, шар үнэг зонхилно (Банников, 1954). Монгол дагуурын хээрийн тойргын амьтны зүйлийн бүрэлдэхүүн, оршин амьдрах хэлбэр, зарим зонхилогч зүйл амьтдын биологи экологийн нарийвчилсан судалгааны дүнд 4 багийн, 14 овгийн, 54 зүйлийн шавж (Murdoch et al., 2006); 1 баг, 4 овгийн 7 зүйл мөлхөгч (Reading et al., 2006a); 14 баг 30 овог, 185 зүйлийн шувуу (Reading et al., 2011); 7 баг 15 овог 28 төрөлд хамаарах 39 зүйлийн хөхтнийг тэмдэглэсэн байдаг (Reading et al., 2013 in press).

Хөхтөн амьтдын зүйлийн бүрдэл, хамгаалагдсан байдал

Дундговь аймгийн Баянжаргалан сумын Хөөтийн хонхор орчмын нутгаас судалгааны явцад тохиолдсон болон өмнөх судлаачдын тодорхойлсоноор тус бүс нутагт тэмдэглэгдсэн 28 зүйл хөхтнөөс 9 зүйл нь агнуурын ач холбогдолтой байна. Монгол орны ховор амьтны жагсаалт, Монгол улсын улаан номд (аргаль хонь, янгир ямаа) 2 зүйл, CITES конвенцийн II хавсралтад (аргаль хонь, мануул мий) 2 зүйл орсон байдаг.

Хоёр нутагтан, мөлхөгчдийн зүйлийн бүрдэл, хамгаалагдсан байдал

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших “Хөөтийн хонхор-2” нэртэй нүүрсний уурхай болон түүний орчмын нутгаас судалгааны явцад хоёр нутагтнаас 1 зүйл монгол бах, мөлхөгчдөөс цоохор хонин гүрвэл, монгол гүрвэл, рашааны могой, бамбай хоншоорт могой гэх 4 зүйл тэмдэглэгдсэн байна.

Эдгээр амьтад олон улсын хэмжээнд үнэлгээ хийгдээгүй байгаа бөгөөд Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийн улаан дансанд “Анхааралд өртөхөөргүй” ангиллаар үнэлэгдсэн байдаг.

Шувуудын зүйлийн бүрдэл

Хөөтийн хонхор орчмын нутгаас судалгааны явцад 9 багт хамаарах 23 зүйл шувууг нүдээр үзэн тэмдэглэсэн байна.

3.2. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 13- Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд төлөвлөсөн ажил

Д/д	Төлөвлөсөн ажил	Биелэлт	Тайлбар
1.	Дүйцүүлэн хамгаалалт хийх газрын хөрс цаг уурын судалгааг хийж суулгахад тоиромжтой мод бут, сөөгийг тодорхойлох төлөвлөгөө гаргах	Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд үйл ажиллагаа явуулж буй Баянжаргалан сумын төвийн урдуун өнгөрөх нүүрс тээврийн замын хажууд ногоон зурвас үүсгэх зорилгоор компанийн зүгээс “Орон нутагт мод тарих” төслийг боловсруулсан. Төсөл нь нийт 3 жилийн хугацаанд хэрэгжих бөгөөд тухайн бүсийн цаг уурт тохирсон мод, сөөгийг тарьж ургуулахаар төлөвлөн, хашаалах талбайг мөн төлөвлөсөн байна.	Боловсруулсан төслийн материалыг биелэлтийн тайлантай хамт хүргүүлэв.
2.	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээнд тариалах модлог ургамлын төрөл зүйлийг өсгөж үржүүлэх плантац, үржүүлгийн талбай, хүлэмж байгуулах бэлчээрийн талбайг ургамалжуулах хашиж хамгаалах		
3.	Хөөтийн булгийн эхийг хашиж хамгаалсан хашааг булгийн эхийг хашиж хамгаалсан хашааг булгийн усны ундаргад нөлөө үзүүлэхээргүй байдлаар дахин хашаалах	2023 онд Хөөтийн булгийн эхийг хашиж хамгаалсан хуучин хашааг 2025 оны 10-р сарын 30-ний өдөр шинэчилэв.	Хашааны зургыг хавсаргав.
	Бүлгийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажил: 3 Хэрэгжүүлсэн ажлын тоо: 3		

Манай “Биг могул коул энд энерги” ХХК нь Хөөтийн булгийн ундаргыг хүн малын хүчин зүйлийн нөлөөллөөс үүдэн бохирдохоос сэргийлж 2023 онд 80 м урттай шургааг модон хашаагаар хашаалсан.

Гэвч 2025 оны 09-р сарын 26-нд булгийн ойр орчмын хог цэвэрлэгээний ажлыг зохион байгуулахаар очих үед 2023 онд булгийн эхийг хашиж хамгаалсан хашааны шургааг модыг ойр орчмын айл өрхийн хүмүүс салгаж ачин, хашааны бүрэн бүтэн байдал алдагдсан байсан тул 2025 оны 09-р сарын 29-ний өдөр хуучин хашааг буулган үлдсэн материалыг уурхай руу ачсан.



